

Суралцагчийн хөгжил, хамгаалал, насан туршийн суралцахуйн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч, Жаргалсайхан Болорчимэг

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Иргэдийн Монгол хэл, бичгийн чадамжийг хөгжүүлэх арга хэмжээг боловсруулж, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлнэ.							
1	Иргэдийн Монгол хэл, бичгийн чадамжийг хөгжүүлэх арга хэмжээг боловсруулж, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлнэ.	15-65 насны иргэдийн ур чадварын үнэлгээг хийх аргачлал, судалгааг боловсруулсан байна.	-	Судалгаа хийх бэлтгэл ажил хангагдсан байна.	Боловсролын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/168 дугаар тушаалаар “Иргэдийн (15-65 нас) монгол хэл, бичгийн ур чадварын түвшинг тодорхойлох судалгаа хийх, судалгааны үр дүнд үндэслэн иргэдийн монгол хэл, бичгийн ур чадварын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, аргачлал боловсруулах, боловсруулсан хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг ашиглан сургалт зохион байгуулах чиглэлээр Насан туршийн суралцахуйн төвийн багш, удирдах ажилтанд цахим сургалт хийх арга хэмжээг хэрэгжүүлэхээр 100 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн батлуулсан. Боловсролын сайдын 2025 оны хөтөлбөр арга хэмжээний жагсаалт шинэчлэн батлах тухай А/220 дугаар тушаалаар “Иргэдийн (15-65 нас) монгол хэл, бичгийн чадамжийг нэмэгдүүлэх ” арга хэмжээний төсөв хасагдсан. Иймээс тус арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, дүүргийн насан туршийн суралцахуйн төвийн	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					цахим хуралд 15-65 насны иргэдийн монгол хэл, бичгийн ур чадварын үнэлгээнд хамрагдах талаар судалгаа, БШУС-ын 2023 оны А/535 дугаар тушаалаар баталсан “Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааны журам”-ын 2.1.8-д “орон нутгийн иргэдийн бичиг үсэг, болон бусад суурь ур чадвар, боловсролд хамрагдалтын тандалт судалгааг 3 жил тутамд хийж, мэдээллийн сан бүрдүүлэх ...” гэж заасны дагуу судалгааг тухайн орон нутгийн байгууллагатай хамтран хийх талаар зөвлөмж, мэдээллийг хүргэсэн. Судалгааг хийхийн өмнө судалгааны судлагдсан байдлыг судлахад Үндэсний статистикийн хорооноос 2014.07.01-ний байдлаар 15–24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь, насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын түвшинг илэрхийлэх статистик мэдээллийг гаргасан байна. 1. 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь /аймаг, нийслэлээр/ https://www.1212.mn/mn/statistic/statcate/573070/table-view/DT_NSO_2800_011V1 2. Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын түвшинг https://www.1212.mn/mn/statistic/statcate/48171323/table-view/DT_NSO_0400_068V1 Хавсралт: 1 файл		
1.2. Малчдын хүүхэд, залуучуудын боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
2	Малчдын хүүхэд, залуучуудын боловсролыг дэмжих арга хэмжээг боловсруулан хэрэгжилтэд зөвлөн тусалж хамтран	Арга хэмжээ боловсруулна. Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	Арга хэмжээ боловсруулан батлуулсан байна. 10	Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/77 дугаар тушаалаар “Малчин өрхийн гишүүний боловсрол, сургалтыг дэмжих” арга хэмжээг баталсан. Тус арга хэмжээг 2024-2028 он хүртэл 21 аймгуудад үе шаттай хэрэгжүүлэхээр төвөлсөн. Малчин өрхийн гишүүний боловсрол, сургалтыг дэмжих арга хэмжээг 2025 онд зүүн бүсийн (Хэнтий, Дорнод, Сүхбаатар) аймгуудад хэрэгжүүлэхээр Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 11-ний А/98 дугаар тушаалаар 150 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын

	ажиллана.				Энэхүү санхүүжилтээр Зүүн бүсийн малчин өрхийн гишүүний боловсролд хамрагдалтын тандалт судалгаа хийх, тухайн аймгийн Политехник коллежтой хамтран мал аж ахуйн чадамжийн гэрчилгээ олгох сургалтыг хамран зохион байгуулах, Энтрепренерт суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх сургалт, Малчин залуу манлайлагч сургалтыг тус тус зохион байгуулж байна. Мөн Малчин залуу манлайлагч сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Дорнод аймгийн Политехник коллежтой хамтран малчин залуучуудад зориулсан сургалтыг үе шаттай амжилтай зохион байгуулж байна. #Мэдээ "Малчин өрхийн гишүүний... - Дорнод Политехник коллеж Facebook Дорнод Политехник коллеж нь малчдад... - Хишигтогтох Лувсан Facebook Хавсралт: 3 файл	12-р сар	үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.1. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, насан туршийн суралцахуйн төвийн албан хаагчдыг ашиглалтын шаардлага хангасан компьютероор хангана.							
3	Насан туршийн суралцахуйн төвийн албан хаагчдыг ашиглалтын шаардлага хангасан компьютертой эсэх судалгаа гаргаж, шаардлагатай албан хаагчдыг компьютертоор хангахад хамтран ажиллана.	Ашиглалтын шаардлага хангасан компьютертой багшийн эзлэх жин	-	Судалгаа хийгдсэн байна.	1. Боловсролын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/166 дугаар тушаалаар "Сонсголын бэрхшээлтэй суралцагчдад зориулсан туслах хэрэглэгдэхүүний тохируулга хийх" туршилтад хамрагдаж буй насан туршийн суралцахуйн төвийн 10 суралцагчдад chromebook хүлээлгэн өгсөн. Баян-Өлгийн аймаг-4, Ховд аймаг-1, Завхан аймаг-1, Хөвсгөл аймаг-1, Өвөрхангай-1, Сэлэнгэ-1, Увс-1 аймгуудад chromebook хүлээлгэн өгч актыг нэгтгэн Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгсөн. 2. Аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн албан хаагчдын ашиглалтын шаардлага хангасан компьютер, тоног төхөөрөмжтэй эсэх, төвийн үйл ажиллагаанд цаашид зайлшгүй хэрэгцээтэй байгаа тоног төхөөрөмжийн жагсаалтыг авч нэгтгэн судалгааг	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ХОХ-д мэйлээр хүргүүлсэн. Хавсралт: 6 файл		
3.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 17.3, 17.4 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 227 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт заасан бодлогын баримт бичгийн төслийг батлуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.							
4	Хөдөлмөрийн тухай хуулийн 17.3, 17.4 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 227 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт заасан бодлогын баримт бичгийн төслийг батлуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.	Бодлогын баримт бичгийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.	Засгийн газрын 2024 оны 227 дугаар тогтоол	Бодлогын баримт бичгийг боловсруулах уулзалт зохион байгуулсан байна	Хөдөлмөрийн тухай хуулийн 17.3-н ажлын хэсгийн хуралд эхний хуралд Насан туршийн суралцахуйн хэлтсээ төлөөлж оролцсон. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 17.4-д "Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэж заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны холбогдох газрын мэргэжилтнүүдтэй уулзаж журмын төслийн зураглал хийж, боловсруулсан төсөлд санал өгч хамтран ажилласан. Өгсөн саналыг тусган дахин журмын төслийг ирүүлсэн. Ирүүлсэн журмын төсөлтэй танилцан санал бэлтгэж тусгаж байна. Энэхүү журам нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санаачлан батлуулах юм. Хавсралт: 1 файл	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах	Батлагдсан журам	-	Журмыг батлуулсан байна.	Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 253/А/123 дугаар хамтарсан тушаалаар "Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах" журмыг баталсан. Журмыг захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэхээр танилцуулга, нөлөөллийн шинжилгээ, хэлэлцүүлгийн тайлангийн хамт ХЭЗХ-д хүргүүлсэн. Хавсралт: 4 файл	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн

	журмыг боловсруулан батлуулна.						хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.3. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл, иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, суралцагч хот (дүүрэг, хороо, аймаг, сум), байгууллагыг дэмжиж ажиллана.							
6	Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл, бүх насны иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөл боловсруулна.	Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, тоогоор	-	50	Боловсролын сайдын 2025 оны А/198 дугаар тушаалаар “эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл, иргэдэд чиглэсэн сургалт нөлөөллийн үйл ажиллагаа” зохион байгуулах тушаалыг баталсан. Энэхүү тушаалаар тухайн орон нутгийн иргэдэд чиглэсэн эх хэл, түүх соёлоо өвлүүлэх, монгол хэл, бичгийн чадварыг хөгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар эзэмшихэд тэгш боломж бүрдүүлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулахад шаардагдах 60 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Тушаалын хэрэгжилтийн хүрээнд аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн 12 төв эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл, иргэдэд чиглэсэн сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах төлөвлөгөө баталсан. Тушаалын хэрэгжилтийн хүрээнд 12 төвтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. Тус сургалт нөлөөллийн ажлын хүрээнд 20 гаруй төрлийн сургалтаар 1000 гаруй эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл, иргэдэд хамруулсан сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна. Хавсралт: 8 файл	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
7	"Суралцагч хот"-ын байгууллагын үйл ажиллагааны	Суралцагч байгууллагын өссөн тоогоор	-	Үйл ажиллагааны төслийг боловсруулсан	1. Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/112 тоот тушаалаар “Суралцагч хот” үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 60 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Тус тушаалаар Олон улсын “Суралцагч хот” арга	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

<p>төслийг боловсруулж, суралцагч байгууллагыг үе шаттай дэмжин арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.</p>			<p>батлуулсан байна.1</p>	<p>хэмжээний шалгуур ханган материал бүрдүүлэлт хийх, хүний нөөцийг чадавхжуулах, иргэдэд чиглэсэн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах, үндэсний хэмжээнд “Суралцагч хот” уралдааныг зохион байгуулах, “Суралцагч хот” гарын авлагыг бэлтгэн гаргах зэрэг үйл ажиллагааг хийхээр төлөвлөн тушаалыг баталсан. 2. Суралцагч хот арга хэмжээний хүрээнд "Насан туршийн суралцахуйн салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа" сургалтад аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн удирдлага, сургалтын менежерүүдийг хамруулан нийт 60 гаруй албан тушаалтныг хамруулсан. 3. Юнескогийн Монголын үндэсний комисстой хамтран “Суралцагч хот хүний нөөцийн чадавхыг сайжруулах нь” сургалтыг Ази номхон далайн орны төлөөллүүдийг урьж оролцуулсан. Тус сургалтаар аймаг, дүүргийн насан туршийн суралцахуйн төвийн удирдлага, багш, ажилтан, орон нутгийн удирдлага, төрийн бус байгууллагын төлөөллүүдийг оролцуулан 80 гаруй хүнийг хамруулан танхимаар зохион байгуулсан. Сургалтад танхимаар оролцох боломжгүй төвийн албан хаагчдад цахимаар хамрагдах боломжийг бүрдүүлэн танхим, цахим хосолсон сургалтыг нийт 100 гаруй албан тушаалтныг оролцуулан зохион байгуулсан. 4.Мөн 2025 онд Юнескогийн “Суралцагч хот”-ын шалгуур хангаж буй Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төв, БГД-ийн Насан туршийн суралцахуйн төвд арга зүйн зөвлөгөө өгч зөвлөн туслах арга зүйгээр ханган өдөр тутамдаа дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна. Суралцагч хот сүлжээнд нэгдэх материалыг бэлтгэн оролцох хүсэлтээ албан бичгээр ирүүлсэн.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 8 файл</p>	<p>6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	<p>даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%</p>
---	--	--	---------------------------	---	---	--

3.4. Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.

8	Насан туршийн суралцахуйн чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааг цахим хуудсанд байршуулна.	Мэдээний тоо	4	Зохион байгуулсан үйл ажиллагааг цахим хуудсанд байршуулсан байна.	Насан туршийн суралцахуйн чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааг 2 удаа байгууллагын цахим хуудсанд байршууллаа. 1. ЮНЕСКО-ийн Суралцагч хотуудын дэлхийн сүлжээнд нэгдэхэд дэмжлэг үзүүлж, оролцогч талуудын чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор “Насан туршийн суралцахуйн салбар чадавх бэхжүүлэх сургалт” зохион байгуулагдаж байна. https://moe.gov.mn/post/165217 2. Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмын төсөлд санал авахаар Боловсролын яамны цахим хуудсанд байршууллаа. https://moe.gov.mn/post/165403 Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	---	--------------	---	--	---	--	---

3.5. Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнана.

9	Насан туршийн суралцахуйн хэлтсийн сарын ажлын тайланг хугацаанд нь тайлагнана.	Тайлангийн тоо	2024 оны гүйцэтгэл	100	Тайлант хугацаанд Насан туршийн суралцахуйн хэлтсийн сарын ажлын тайланг 5 удаа гарган гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санд тайланг бичиж, хугацаанд нь тайлагнасан. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	---	----------------	--------------------	-----	---	--	--

10	Насан туршийн суралцахуйн хэлтэст сайдын шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнана.	Тайлангийн тоо	4	100	Боловсролын сайдын шуурхай хурлаас Насан туршийн суралцахуйн хэлтэстэй холбоотой 10 үүрэг даалгавар өгсөн байна. Сайдын үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухай бүр тайлагнасан. Мөн Сайдын шуурхай хуралд танилцуулагддаг Боловсролын салбарын мэдээллийг харьяа байгууллагаас авч PPT-ийг нэгтгэн сайдын шуурхай хуралд бэлтгэдэг. Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
----	--	----------------	---	-----	--	--	--

3.4. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх

11	Хариуцсан чиглэлийн хүрээнд албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэж хуулийн хугацаанд ХАСХОМ мэдүүлгийг хугацаанд нь мэдүүлнэ.	Архивласан боть, албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тоо, ХАСХОМ мэдүүлэг	2024	Хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хариуцсан чиг үүргийн хүрээнд 10 албан бичиг, 2 өргөдөл гомдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн холбогдох байгууллагад хариу хүргүүлсэн. Тайлант хугацаанд нийт 22 албан бичиг, тушаалыг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн. Хуулийн хугацаанд ХАСХОМ мэдүүлгийг хугацаанд нь мэдүүлсэн. 2024 онд үүссэн баримтыг архив албан хэрэг хөтлөлтийн хууль, нийтлэг журмыг баримтлан эмхлэн цэгцэлж, хадгаламжийн нэгж үүсгэн архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа
----	--	--	------	-------------------------------	---	--	---

							гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	--	--------------------------------

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Монгол кирил бичгийн үсгийн дүрмийн мэдлэг ур чадвараа сайжруулна.	Монгол кирил бичгийн үсгийн дүрмийн мэдлэг ур чадвараа сайжруулна.	-	Монгол кирил бичгийн үсгийн дүрмийн мэдлэг ур чадвараа сайжруулна.	Монгол бичгийн үсгийн дүрмийн мэдлэг ур чадвараа сайжруулахаар Сонгинохайрхан дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн зохион байгуулдаг "Төрийн албан хаагчид үндэсний бичгийн сургалт"-д онлайнаар хамрагдаж мэдлэгээ нэмэгдүүлсэн. Хавсралт: 1 файл	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%
2	Эрхлэх асуудалд хамаарах шинээр батлагдсан	Судалсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр	-	5	БЕХ-ийн 26.1.3-д "иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг судлаж, мэдээллийн сан үүсгэнэ.	(тоогоор)			<p>гишүүнтэй хамтран батлах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 17.4-д "Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэж заасны дагуу журмын төслийг боловсруулахад дараах баримт бичгүүдийг судаллаа. үүнд. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 227 дугаар тогтоолоор баталсан "Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц", БШУСС-ын 2018 оны А/168 дугаар тушаалаар "Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам", БШУС-ын 2021 оны А/88 дугаар тушаалаар "Бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр", БШУСС-ын 2019 оны А/156 тоот тушаалаар батлагдсан "суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам", БШУС-ын 2024 оны А/128 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам", БШУС-ын 2024 оны А/216 дугаар тушаалаар баталсан "Дээд боловсролын сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журам", БЕГ-ын даргын 2024 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Гадаад улсын эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас монгол улсын боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах тохиолдолд суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлж, дүйцүүлэх, багц цаг тооцох журам", БШУС, ХНХС-ын 2023 оны хамтарсан А/513,А/171 дүгээр тушаалаар баталсан "Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журам", БШУС-ын 2024 оны А/262 дугаар тушаалаар баталсан "Төрөлжсөн сургалт зохион байгуулах журам" зэрэг</p>	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ: 90%
--	-----------	--	--	---	--	---------------------

					эрх зүйн баримт бичгийг уншиж судаллаа. Хавсралт: 1 файл		
3	Боловсролын асуудлаар гарч буй олон улсын судалгааны ажил, тайлан уншиж мэдлэгээ дээшлүүлнэ.	Уншиж судалсан ном, гарын авлага, тайлан, судалгаа (тоогоор)	-	2	Дэлхийн сүлжээ суралцагч хотын хүрээнд боловсруулан гаргаж буй "Суралцагч хот" гарын агуулга, мэдээллийг уншиж мэдлэгээ нэмэгдүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээнд туссан "15-65 насны иргэдийн монгол, хэл бичгийн чадварыг РIAAC-д үнэлэх" ажлын хүрээнд хэрхэн үнэлэгээнд хамрагдах, ямар асуултын хүрээнд үнэлэх зэрэг мэдээллийг судалсан. https://www.oecd.org/en/about/programmes/piaac.html Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%
4	Байгууллагын тогтмол зохион байгуулагддаг мэдээллийн цагт хамрагдаж мэдлэгээ нэмэгдүүлнэ.	Хамрагдсан мэдээллийн цаг (тоогоор)	2024 оны хамрагдалт	Зохион байгуулсан мэдээллийн цагт хамрагдсан тоо	Байгууллагын тогтмол зохион байгуулагддаг мэдээллийн цагт хамрагдаж мэдлэгээ нэмэгдүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн хөгжил, хамгаалал, насан туршийн суралцахуйн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч, Жаргалсайхан Болорчимэг

/...../

Огноо: